



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 дугаар сарын 18 өдөр

Дугаар 59

Хэрлэн сум

LIХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 59 дүгээр хуралдаан 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Улаанбаатар хот болон халдвар голомтлон гарсан бүс, орон нутгаас ирж буй иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох эсэх талаар хэлэлцэх,

*Аймгийн Ерөнхий тархвар судлаач эмч,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

2.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан сум хоорондын хөдөлгөөнийг зохицуулах талаар сумын Онцгой комиссоос ирүүлсэн саналыг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

3.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан Дорнод аймгийн хэмжээнд халдварын тархалтын "Улбар шар" түвшинд шилжүүлэх эсэх талаар хэлэлцэх,

*Эрүүл мэндийн газар*

4.Хот хоорондын нийтийн тээврийн автобусыг зогсоосон талаар шийдвэр гаргуулах,

*Авто тээврийн төв*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д

1.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллагуудын хоолны газруудын үйл ажиллагааг түр хугацаагаар хаах талаар байгууллагуудад чиглэл өгөх,

*М.Бадамсүрэн  
Тхүр Г.Нармандах*

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.2.Улаанбаатар-Чойбалсан чиглэлийн хот хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаатай хязгаарлах тухай саналыг Улсын Онцгой комисст албан бичиг хүргүүлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа,


Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.3.Улаанбаатар-Чойбалсан чиглэлийн хот хоорондын иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зайлшгүй хүндэтгэн үзэх шалтаан /эрүүл мэндийн 13А, Б, буяны ажил /төрсөн аав, ээж, ах дүү, хүүхэд/, үндсэн харьяандаа ирэх, буцах, үндсэн ажлын байрандаа ирэх, очих/, зөвшөөрөгдсөн ажил, үйлчилгээ /мал аж ахуй, газар тариалан, хүнсний ногоо жимс, уул уурхай, газрын тосны ашиглалт, барилга зам, эрчим хүч, харилцаа холбооны бүтээн байгуулалт, засвар арчлалт/, зөвшөөрөгдсөн тээвэр /шуудан карго, хүнс, эм эмнэлгийн хэрэгсэл, барилгын материал, шатахуун, тос тосолгооны материал, уул уурхайн бүтээгдэхүүн, техник тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл, цахилгаан бараа, гэр ахуйн тавилга, мал амьтны тэжээл, мал мах/-ийг зөвшөөрөлтэй нэвтрүүлэх бусад тохиолдолд 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 10 хоногийн хугацаатай хязгаарлах,

1.4.Сум хоорондын иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зайлшгүй хүндэтгэн үзэх шалтаан /эрүүл мэндийн 13А, Б, буяны ажил /төрсөн аав, ээж, ах дүү, хүүхэд/, үндсэн харьяандаа ирэх, буцах, үндсэн ажлын байрандаа ирэх, очих/, зөвшөөрөгдсөн ажил, үйлчилгээ /мал аж ахуй, газар тариалан, хүнсний ногоо жимс, уул уурхай, газрын тосны ашиглалт, барилга зам, эрчим хүч, харилцаа холбооны бүтээн байгуулалт, засвар арчлалт/, зөвшөөрөгдсөн тээвэр /шуудан карго, хүнс, эм эмнэлгийн хэрэгсэл, барилгын материал, шатахуун, тос тосолгооны материал, уул уурхайн бүтээгдэхүүн, техник тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл, цахилгаан бараа, гэр ахуйн тавилга, мал амьтны тэжээл, мал мах/-ийг зөвшөөрөлтэй нэвтрүүлэх бусад тохиолдолд 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 10 хоногийн хугацаатай хязгаарлах,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан халдвар илэрсэн объект, байршлыг үндэслэн аж ахуй нэгж байгууллага, хуулийн этгээд, иргэний зарим үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 10 хоногийн хугацаатай тусгай горимоор мөрдүүлэх тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

 /М.Бадамсүрэн  
/Хүр Г.Нармандах

2.2.Төрийн албан хаагчдыг коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан гэр, ажил гэсэн маршрутаас бусад чиглэлд зорчихыг хориглох талаар аймгийн Онцгой комиссын тогтоолд тусгах,

Аймгийн Засаг даргын зөвлөх, Онцгой комиссын гишүүн Х.Энх-Отгон,

АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга,

Онцгой комиссын гишүүн Э.Батболд нарт:

2.3.Аймгийн Онцгой комиссын хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэрүүдийг тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд шуурхай мэдээлж ажиллах,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын дарга,

Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-д:


2.4.Хэрлэн суманд үйл ажиллагаа эрхэлдэг цэцэрлэгүүдийн тоглоомын талбайг иргэдийн салхлах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй байлгах талаар байгууллагын удирдлагуудад нь чиглэл өгөх,

2.5.Хэрлэн сумын харьяатай хяналтын цэгийн гадна оршин суудаг малчин иргэдэд Хэрлэн сумын Онцгой комиссоос тодорхойлолт олгож хяналтын цэгээр нэвтрүүлэх,

Гурав.Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын

гишүүн Ц.Мөнхтөр-д:

3.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан Улаанбаатар-Чойбалсан чиглэлийн хот хоорондын нийтийн тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 10 хоногийн хугацаатай түр хязгаарлахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ  
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОВЛОГЧ  
ДАРГА, ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ